

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээ

**ӨСВӨР НАСНЫ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ
ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ**

**INTERNATIONAL STANDARDS ON OTHER PENALTIES FOR JUVENILE
PERSONS**



Д.Одсэр

401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн

эмнэлгийн дарга, удирдахуйн ухааны магистр, хурандаа

Товч утга: Өгүүлэлд өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан олон улсын хэм хэмжээний ойлголт, төрөл, ангиллын талаар тайлбарласан.

Түлхүүр үгс: хорихоос өөр төрлийн ял, өсвөр насны хүн, олон улсын хэм хэмжээ, хяналт.

Abstract: The article describes the concepts, types, and classifications of international norms that other penalties for juvenile persons.

Keywords: non-custodial sentences, juveniles, international norms and controls.

Өсвөр насны хүний гэмт явдал нь нийгмийн тусгайлсан динамик үзэгдэл бөгөөд нийт гэмт явдлын хувьд аюултай “нөөц” гэж хэлж болох юм. Хууль зөрчигчийн насанд хүрээгүй байдлыг гэмт үйл хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн эрүүгийн эрх зүйн арга хэмжээний онцлогууд тодорхойлдог гадна нийгмийн, насны, сэтгэл зүйн болон бие бялдрын шинж чанараас хамаарсан энэ төрлийн иргэдэд хандах онцгой хандлага ч тодорхойлдог байна.

Насанд хүрээгүй хүний гэмт явдал нь дийлэнх нь орнуудын анхаарлын төвд байдаг асуудлуудыг нэг юм.

Э.Б. Мельникова “насанд хүрээгүй хүн” гэж өөрийн наснаас хамааран амьдралд хүлээн зөвшөөрөгдөхгүйгээс шалтгаалан тодорхой онцлог бүхий эрх,

үүрэгтэй бүлэг хүмүүсийг хэлдэг бөгөөд тэдний эрхийг хамгаалах эрх зүйн тогтвортой үндсийг боловсруулах шаардлагатай гэж үзсэн⁹⁴.

Энэ асуудлын хүрэн дэх олон улсын хамтын ажиллагаа нь насанд хүрээгүй хүнд эрүүгийн ял оногдуулах, түүнийг хэрэгжүүлэхэд хамаарсан олон улс, орнуудын туршлагад суурилсан суурь олон улсын баримт бичгийг боловсруулахад хүргэсэн. Үүнтэй холбогдуулан бидний судалж буй салбарын хүрээнд олон улсын баримт бичиг боловсруулах Нэгдсэн Үндэсний Байгууллагын голлох чиг үүрэг болсон юм.

Бидний судалж буй өсвөр насны хүний онцлогийг тодруулахын зэрэгцээ олон улсын байгууллагаас гэмт хэрэгт сэжиглэгдэж буй, буруутгагдаж буй, ял эдэлж буй насанд хүрээгүй хүмүүст хамаарах олон улсын баримт бичгийг боловсруулсан юм. Тэр дундаас Хүүхдийн эрхийн тунхаглал 1959 он, Хүүхдийн эрхийн тухай конвенци 1989 он.

Насанд хүрээгүй хүнд оногдуулах эрүүгийн ял нь олон улсын баримт бичгийн зарчимд бүрэн нийцсэн байх учиртай. Гэсэн хэдий ч дээр дурдсан олон улсын актууд нь өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх ажиллагааг зохицуулаагүйг тэмдэглэх хэрэгтэй.

Олон улсын баримт бичгийг судлахын өмнө насанд хүрсэн болон насанд хүрээгүй бүхий л хүмүүст хамааралтай хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жижиг дүрмүүд буюу Токиогийн дүрмүүдийг нэрлэх нь зүйтэй. Бидний судалгааны хүрээнд бид зөвхөн насанд хүрээгүй буюу өсвөр насны ялтнуудын талаар судлах юм.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны олон улсын эх сурвалж:

Хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн асуудлаар 1990 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” Токиогийн дүрмийг батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал дүрэм болсон билээ. Токиогийн дүрэм⁹⁵ нь Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 сарын 14-ний өдрийн 4(110) дугаар тогтоолоор 7 бүлэг 23 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд уг дүрмээр хорих ялын хэрэглээг багасгах, эрх зүйн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгыг агуулж, нийгмийн болон

⁹⁴ Мельникова Э.Б. Ювенальная юстиция. Проблемы уголовного права, уголовного процесса и криминологии : учеб. пособие. М., 2000. 11 дэх тал.

⁹⁵ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012. 159 дэх тал.

хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалахыг анхаарч шаардлагатай тохиолдолд хохирогчтой зөвлөлдөж байхыг зөвлөжээ.

Энэхүү Токиогийн дүрмээр хорихоос өөр төрлийн арга хэмжээнд хэрэглэгдэх зарчмуудыг тусгасан юм. Үүнд:

- Хорихоос өөр төрлийн ял хэрэглэж байгаа этгээдүүдийн хувьд наад захын баталгааг агуулах, ЭБША-г хэрэгжүүлэх
- Эрх зүйн зөрчил гаргагч этгээдэд хандахад олон нийтийн идэвхтэй оролцоог хангах;
- Эрхийн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн бодлого зорилтыг харгалзан хэрэглэгдэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн аюулгүй байдлын тухайд нийгмийн сонирхол, хохирогчийн эрх, зөрчил гаргагчийн эрхийн хооронд зүй зохистой харьцааг хангах;
- Хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, нийгмийн шударга ёсны шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн хууль тогтоомж дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулах зорилготой.

Дүрэм нь хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх, түүний зарчмыг тодорхойлох, шийтгүүлсэн этгээдүүдийн хувьд наад захын баталгаануудыг агуулдаг. Энэхүү дүрмийн гол онцлог нь эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдүүдийг нийгмийн хэвийн амьдралд түргэн эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүүтэй дахин хэрэг зөрчил үйлдэж давтан гэмт хэрэгтэн болох явдлаас сэргийлж, төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлж авахыг илүүд үзжээ. Үүнээс гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь үр дүнгээ өгч байгаа тохиолдолд эрх зүйн зөрчил гаргагч этгээдийн хугацаанаас нь өмнө уг арга хэмжээг зогсоох, уучлах, үр дүнд хүрээгүй тохиолдолд шууд хорих ял хэрэглэхээс зайлсхийж дахин хорихоос өөр төрлийн ял шийтгэлээс сонгохыг санал болгож урамшуулах, уучлах, өршөөх, ажил сургалттайн холбогдуулж чөлөө олгох механизмыг тогтоож өгсөн байна.

Дээрх зохицуулалтаас гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэгч тогтоол гүйцэтгэгчийн хувьд нарийн тодорхойлж амьдралын туршлагатай, мэргэжлийн зохих бэлтгэлтэй, хувийн шинж чанараар тохирсон хүн байвал зохино хэмээн тусгайлан тодорхойлсон нь ихээхэн анхаарал татсан юм.

Эдгээрээс үзэхэд хорихоос өөр төрлийн арга хэмжээ авагдсан этгээдийн сэтгэл зүйн байдалд ихэд анхаарч тусгайлсан мэргэжилтэн, сэтгэл зүйч бэлтгэхээс гадна олон нийтийн оролцоо уг арга хэмжээнд зайлшгүй чухал гэдгийг ухамсарлуулах зорилгоор онол практикийн бага хурал, семинар, бусад арга хэмжээг байнга зохион байгуулж ажиллахыг мөн зөвлөжээ.

НҮБ-ын гишүүн орнууд эрүүгийн хууль тогтоомждоо дээр дурдсан зарчмыг баримталж, хорих ялаас татгалзаж хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх, уг ялыг хэрэглэхдээ олон нийтийн оролцоог сайжруулж, зөрчил гаргагч этгээдийн нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг нэмэгдүүлж, эргээд нийгэмд хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, зөрчил гаргагч, хохирогч этгээдийн эрхийн хооронд зүй зохистой харьцааг хангаж, үндэсний хууль тогтоомж, нийгмийн шударга ёсны шаардлагад нийцүүлж хуульчлах шаардлагатайг дурдсан байгаа нь тус ялыг эдлүүлэх ажиллагааны тогтолцоог илэрхийлсэн гэж үзэж болох юм.

Олон улс үндэстэн эрүүгийн эрх зүйд хүний эрхийг хангаж, хүнлэг, энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж ялын хатуу чанга ял шийтгэлээс татгалзаж, хүмүүжил олгох хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна. Уг байр суурийг ч мөн НҮБ өөрийн олон улсын баримт бичигт тусгах замаар гишүүн орнуудад үүрэг болгожээ.

Тиймдээ ч хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүйг дэлхий нийт хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас нь шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах хандлагатай байна.

Токиогийн дүрмүүдийг боловсруулах гол учир нь хорих ялыг орлох өөр ялын төрлийн хэрэглэхэд оршсон. Энэ дүрмүүдэд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний баталгаа, эрх, хууль ёсны ашиг сонирхол зэргийг агуулдаг. Хорихоос өөр төрлийн ялыг ялтны хувийн байдал, түүнчлэн хохирогчийн эрх, шийтгэлийн зорилгод нийцэн тогтоогдсон шалгууруудад үндэслэн ялын төрлийг сонгодгийг тэмдэглэх хэрэгтэй⁹⁶.

Дүрмүүд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэх, ялангуяа эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандахад олон нийтийн илүү идэвхтэй оролцоог хангах, түүнчлэн эрхийн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгыг агуулдаг байна.

⁹⁶ Токиогийн дүрмүүдийн 3.2 дугаар дүрэм.

М.Р. Гета хорихоос өөр төрлийн ял нь зөвхөн бие даасан институт бус харин гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн бүхэл бүтэн арга хэрэгсэл юм гэсэн байдаг⁹⁷.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг нийгэмд зүгээр орхилгүй хорихоос өөр төрлийн ял оногдуулж, олон нийтийн байгууллага, сайн дурын ажилтнуудыг татан оролцуулах чухал ач холбогдолтой. Харин үр дүнд нь ялын засрал хүмүүжил чөлөөт нийгэмд болох учиртай.

1990 оны Токиогийн дүрмүүдэд ялтанд тавих хяналтын гол зорилго нь давтан гэмт хэргийг бууруулах, нийгмийн амьдралд нь дэмжлэг үзүүлэхэд оршино гэж заасан.

Шаардлагатай тохиолдолд өсвөр насны ялтанд нийгмийн, сэтгэл зүйн болон хууль зүйн дэмжлэг үзүүлдэг байна. Өсвөр насны хүнд оногдуулсан үүрэг, хязгаарлалт нь түүний, хохирогчийн болон нийгмийн ашиг сонирхлыг харгалзан үзсэн тодорхой байх ёстой. Ялын зорилгод хугацаа дуусахаас өмнө хүрсэн тохиолдолд хорихоос өөр төрлийн ялаас хугацаанаас өмнө суллагдах боломжтой байдаг.

Токиогийн дүрмүүдэд ялтнуудад бүлгийн болон ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах арга зүйг боловсруулахдаа төрөл бүрийн хууль зөрчигчидтэй тусгайлан харьцах хэрэгтэй болохыг заавал харгалзан үзэх нь оновчтой гэж тэмдэглэсэн байна.

Хэрэг ялтан оногдуулсан ялыг эдлүүлэх журмыг зөрчсөн тохиолдолд ялыг зогсоох эсхүл өөр ялаар сольдог байна. Хэрэв ялтанд үзүүлэх ялын үр нөлөө үнэхээр бага байгаа бол нэн даруй хорих ялаар солих зөвлөмжийг олон улсын баримт бичгүүдэд тусгасан байдаг.

Шүүхээс хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн өсвөр насны хүнд хяналт тавьж байгаа албан хаагч нь ялтан бүрийн засрал хүмүүжлийн түвшинд үнэлгээ өгөх чадвар бүхий мэргэжлийн бэлтгэлжилттэй байх ёстой.

Үүний зэрэгцээ олон улсын баримт бичигт тусгагдсан зөвлөмжийг үл тоох хэрэггүй бөгөөд үндэсний хууль тогтоомждоо аль боломжтой байдлаар тусгах хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан олон улсын баримт бичгийг судлахын зэрэгцээ Европын Холбооны “Насанд хүрээгүй хүнд хэрэглэсэн эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээний талаар Европын дүрмүүд”ийг судлах хэрэгтэй. Энэ дүрмүүдийг 2008 онд Бээжингийн болон Токиогийн дүрмүүдийн заалтуудыг харгалзан үзэж

⁹⁷ Гета М.Р. Альтернативы наказанию. М., 2004. С. 22-27.

боловсруулсан бөгөөд өсвөр насны гэмт хэрэгтэнд хэрэглэх нийгмийн санкци, арга хэмжээнүүдийн үндсэн зарчмууд, эрх зүйн хэм хэмжээг тогтоосон байна. Нийгмийн санкцид таслан сэргийлэх арга хэмжээнээс бусад өсвөр насны хүнд эрх чөлөөтэй, тодорхой хязгаарлалтыг дагаж мөрдөх аливаа арга хэмжээг хэлнэ гэж баримт бичигт дурдсан байна.

Иймд, өсвөр насны хүний насны ангиллыг харгалзсан хорихоос өөр төрлийн ялын олон сонголттой байхыг улс орнуудад зөвлөсөн байдаг байна.

Европын дүрмүүд нь өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх үндсэн зарчмуудыг тогтоосон байна. Үүнд:

- насанд хүрээгүй ялтны эрхэд хүндэтгэлтэй хандах;
- нийгмийн нэгдмэл байдал, хүмүүжүүлэх, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарчмууд нь тухайн хүмүүсийн ангилалд хамаарах ялыг хэрэгжүүлэхэд үндэс суурь байх ёстой;
- ял эдлүүлэхдээ өсвөр насны ялтан бүрийн онцлогийг (сонирхол, сэтгэл зүйн байдал), үйлдсэн гэмт хэргийн байдал, хэрэв шаардлагатай бол сэтгэл зүйн байдал, түүний талаар судалсан материал зэргийг харгалзан үзэх ёстой;
- ял эдлүүлэх явцад ямар нэгэн үндэслэлээр өсвөр насны хоригдлыг ялгаварлан гадуурхаж болохгүй;
- ялтны ашиг сонирхолд нийцээгүйгээс бусад тохиолдолд өсвөр насны ялтанд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх түүний эцэг эх болон бусад хууль ёсны төлөөлөгчдийг татан оролцуулах нь зөв гэж зөвлөсөн байна⁹⁸.

Ялтны эрхэд хүндэтгэлтэй хандах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмууд нь бүх насны ялтнуудад хамааралтай гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Өсвөр насны хүнд оногдуулсан ялыг эдлүүлэх ажиллагааны онцлогийг дараах зарчмууд тодорхойлдог: хүмүүжүүлэх, насны ангиллыг харгалзан хүн бүртэй ажиллах замыг тодорхойлох, ялтны ашиг сонирхолд нийцээгүйгээс бусад тохиолдолд ял эдлүүлэх ажиллагаанд эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчдийг татан оролцуулах зэрэг.

Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаар дүрмүүдэд тусгасан байна. Үүнд:

- эрх бүхий байгууллагаас өсвөр насны ялтны эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчид ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн зорилго, агуулгын талаар тайлбар өгөх үүрэгтэй;
- ял эдлүүлэх байгууллагаас өсвөр насны ялтны эцэг, эх эсхүл хууль ёсны төлөөлөгчидтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэх;
- өсвөр насны хүнд оногдуулсан арга хэмжээнээс хамааран түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчид эрх, үүрэг оногдуулах зэрэг.

⁹⁸ <https://www.refworld.org/cgi-bin/texis/vtx/rwmain/opensslpdf.pdf?reldoc=y&docid=4d7882552>

Европын дүрмүүд нь хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ял эдлүүлэх наад захын нөхцөлийг тогтоодог. Эдгээрээс хамгийн чухал гэснийг судлан үзье.

1. Төрөөс өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх олон сонголттой буюу хүмүүжүүлэх, нийгмийн хэм хэмжээнд нийцсэн дадал эзэмшүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг өсвөр насны хүнтэй зөвлөлдөх журмыг тогтоох хэрэгтэй.

2. Ял эдлүүлэх явцад нийгмийн эерэг харилцааг анхаарч өсвөр насны хүн болон түүний гэр бүлийн харилцааг тогтоох нь зүйтэй.

3. Өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх нөхцөл, журмыг талаар төрөлх хэл дээр танилцуулах.

4. Үндэсний хууль тогтоомжид өсвөр ялтан ял эдлүүлэх нөхцөлийг өөрчлүүлэх талаар хүсэлт (амаар эсхүл бичгээр) гаргах эрхийг тусгах ёстой.

5. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх байгууллага нь ялтан бүрд хувийн хэрэг нээж, тогтмол баяжилт хийн, зохих журмыг дагуу хадгална.

6. Өсвөр насны ялтнаар нийтэд тустай ажил хийлгээд:
- ял эдлүүлэхдээ ашиг олохыг зорилго болгохгүй;
- ажил хийлгэх нөхцөл, журам нь хөдөлмөрийн болон эрүүл мэндийн тухай хуульд нийцсэн байх ёстой.

7. Өсвөр насны ялтныг нийтэд тустай ажил хийлгэхдээ аливаа тохиолдол, гэмтэл авахаас урьдчилан сэргийлж датгуулах хэрэгтэй.

8. Өсвөр насны ялтан, түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчид ял эдлүүлэх ажиллагааны зардлыг төлөх ёсгүй.

9. Хэрэв өсвөр насны ялтан гадаадын иргэн бол түүнд эрх, үүргийг тайлбарлан харьяалагдах улсад шилжүүлэн өгнө.

Өсвөр насны хүнд оногдуулсан санкц, хязгаарлалтын арга хэмжээнүүд нь боловсрол эзэмших үйл явцад саад учруулахгүй байх ёстой. Өсвөр насны хүнийг хүмүүжлийн нөлөө үзүүлэх арга хэмжээнд ач холбогдол өгдөг байна.

Үүнээс гадна өсвөр насны хүнд хэрэглэх журам, өсвөр насны хүн, түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөл хэрэгтэй тохиолдлын талаар үндэсний хууль тогтоомжид тусгах хэрэгтэй.

Насанд хүрээгүй хүмүүсийн боловсролын үйл ажиллагаа, мэргэжлийн боловсрол, нийгмийн хамгаалал, тэтгэмж авах, бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийг нь хамгаалах, шийтгэл, хязгаарлах арга хэмжээ авах эрхийг өчүүхэн төдий хэмжээгээр зөрчихөд хүргэх нөхцөл байдлаас бүх талаар зайлсхийх шаардлагатай⁹⁹.

⁹⁹ Мөн тэнд.

Европын дүрмүүдэд өсвөр насны хоригдол тогтоосон нөхцөл, үүргийг биелүүлээгүй тохиолдолд дараах үндсэн хэм хэмжээг тогтоосон байна.

Нэгдүгээрт, ялын нөхцөл, журмыг биелүүлээгүй, ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд ирэх үр дагаврын талаар ялтан, түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчдөд заавал танилцуулах хэрэгтэй.

Хоёрдугаарт, үндэсний хууль тогтоомжид өсвөр насны ялтан ялын нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх байгууллагын ажилтан хэрхэн ажиллах талаар зохицуулалтыг тусгах шаардлагатай.

Гуравдугаарт, өсвөр насны ялтны хувийн хэрэгт бага ч хамаагүй зөрчлийн талаар тэмдэглэх хэрэгтэй. Ялтан ноцтой зөрчил гаргасан тохиолдолд энэ талаар шийдвэр гаргах субъектэд нэн даруй мэдэгдэх хэрэгтэй. Ингэхдээ эрүүгийн ял эдлүүлэх байгууллага шаардлагатай мэдээллийг (зөрчил гаргах нөхцөл, өсвөр насны хүний зан байдлын тодорхойлолт) агуулсан тайланг гаргадаг. Шаардлагатай тохиолдолд өсвөр насны хүнд сэтгэл зүйн, сэтгэц зүйн сорилыг зохион байгуулна.

Дөрөвдүгээрт, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчсөн талаар хавтаст материалтай өсвөр насны ялтан, түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчийг заавал танилцуулна.

Тавдугаарт, өсвөр насны хүний эдэлж буй ялыг өөрчлөх, зогсоох талаар асуудлыг шийдвэрлэхдээ юуны өмнө тэр бүх тогтоосон үүргийг биелүүлж байсан эсэхийг тогтоох, харин үүний дараагаар гаргасан зөрчлийн хүнд, хөнгөн байдлаас хамааран авах арга хэмжээг шийдвэрлэнэ¹⁰⁰.

Иймд, 2008 оны Европын дүрмүүд нь өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тогтоодог ба голлох байр суурийг нийгэмд дасан зохицуулах, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэл эзэлдэг. Мөн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны онцлогийн талаар тусгасан байна.

Үүний зэрэгцээ өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд тэдний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчдийн эрх зүйн байдлыг тодорхойлохыг зөвлөдөг байна.

Дээр дурдсан олон улсын баримт бичгүүдээс гадна өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны асуудлыг бусад актуудад тусгалаа олсон байна. Энэ талаар бид товчлон судлан үзье.

¹⁰⁰ Мөн тэнд.

Европын Холбооны сайд нарын хорооны **“Пробацийн тухай Европын дүрмүүд” зөвлөмж № гес(2010)1**-т нийтэд тустай ажил хийлгэх нь ял болохын хувьд ямар нэгэн доромжлон гутаасан шинжтэй байж болохгүй. Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахдаа ялтанд өөрийн хөдөлмөрлөх чадвар, дадлыг хөгжүүлэх боломжийг харгалзан үзэх хэрэгтэй (47 дахь хэсэг)¹⁰¹.

Дүрмүүдэд өсвөр насны хүмүүсээр хийлгэх нийтэд тустай ажлыг олон төрөлтэй байлгах болон нийтэд тустай ямар хийх сонирхолтой байгааг харгалзан үзэх хэрэгтэй гэж заасан (51 дэх хэсэг).

Мөн дүрмүүдэд ялтны гэр бүлтэй шууд болон бусад байгууллагаар дамжуулан ажиллахын ач холбогдлын талаар бичсэн байдаг (56 дахь хэсэг).

Европын Холбооны сайд нарын хорооны **“Нийгмийн санкц, арга хэмжээний тухай Европын дүрмүүд” зөвлөмж № гес(2017)**-ийн талаар дурдах нь зүйтэй. Энэ зөвлөмжийг боловсруулахдаа Пробацийн тухай Европын холбооны дүрмүүд (2014), Цахим хяналтын тухай Европын дүрмүүд (2014), Токиогийн дүрмүүдийн (1990) зарчмуудыг үндэс болгосон нь хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэх нэгдсэн, олон улсын хандлагыг боловсруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулсан байна.

Энэ олон улсын актад хорихоос өөр төрлийн ял оногдуулах үндсэн зарчмууд, хэрэглэх эрх зүйн үндэс, ял эдлүүлэх журам, нууцлалыг хангах арга хэмжээ, олон нийтийн оролцоо, шүүхээс тогтоосон хязгаарлал, үүргийн биелүүлээгүй тохиолдолд гарах үр дүн, ял эдлүүлэх байгууллагын албан хаагчид тавигдах шаардлагын талаар тусгасан байдаг.

Мөн дүрмүүдэд нийтэд тустай ажил агуулгын хувьд ялтны ажлын мэргэшлийн түвшинг аль болох нэмэгдүүлэхэд анхаарч, ач холбогдол өгсөн байдаг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын № 29 Конвенцид шүүхийн шийдвэрээр хийгдэж байгаа аливаа ажилд хяналт эсхүл төрийн байгууллагаас хяналт тавих шаардлагатай бөгөөд ялтныг хувь хүн, компани эсхүл нэгдэлд шилжүүлэн өгч болохгүй. Монгол Улсын хувьд нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн хүний ажлын бүртгэлийг ажил хийлгэхээр гэрээ байгуулсан байгууллага хариуцдаг байна. Нөхцөл байдлыг манай орны нутаг дэвсгэрийн хэмжээ болон зарим орон нутагт шийдвэр гүйцэтгэх хэлтэс байхгүй нь хүндрүүлдэг байна. Эдгээр нь нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөнд сөргөөр нөлөөлдөг байна.

¹⁰¹ <http://www.consultant.ru/cons/cgi/online.cgi?req=doc&base=INT&n=58510#09198428253691164>

Олон улсын баримт бичгийн агуулгад дүн шинжилгээ хийж өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх онцлог хэм хэмжээг тэмдэглэж болох юм. Үүнд:

- үндэсний хууль тогтоомжид хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн өсвөр насны ялтныг хүмүүжүүлэх талыг давамгайл байлгах нь зүйтэй;

- өсвөр насны хүнд оногдуулсан хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа нь өсвөр насны хүнийг боловсрол эзэмшихэд хүндрэл учруулж болохгүй;

- хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэхдээ өсвөр насны ялтны насны ангиллыг харгалзан харилцах хэрэгтэй;

- өсвөр насны ялтны зан үйлд эерэг үр дүн гарсан эсхүл эрүүгийн хариуцлагын нийгэмшүүлэх зорилгод хугацаанаас өмнө хүрсэн бол ялын нөхцөлийг зөөлрүүлэх, багасгах, хугацаанаас өмнө чөлөөлөх боломжийг бүрдүүлэх;

- өсвөр насны ялтны ашиг сонирхолд харшлаагүй бол түүний эцэг эх, эсхүл хууль ёсны төлөөлөгчийг татан оролцуулах;

- өсвөр насны хүнийг засан хүмүүжүүлэх, нийгмийн олон бусад туслалцаа үзүүлэх ажилд олон нийтийг идэвхтэй татан оролцуулах;

- Өсвөр насны ялтныг нийтэд тустай ажил хийлгэхдээ аливаа тохиолдол, гэмтэл авахаас урьдчилан сэргийлж датгуулах хэрэгтэй зэрэг.

---o0o---